### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь Монгол орны ургамал нөмрөгийн өвөрмөц байдлыг шингээсэн, олон улсын жишигт нийцсэн ботаникийн цэцэрлэгийг бүтээн байгуулах, байгалийн ургамлын генийн санг хадгалж хамгаалах, Монгол орны ургамлын аймаг, ангилал зүй, экологи, биологийн онцлог, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох экосистем /ургамалжил/-ын чиг хандлага, үйлчилгээний чиглэлээр инновац, шинэ мэдлэг буй болгох суурь болон хавсарга судалгааг хослуулан хөгжүүлэх байгууллага юм.

Тус хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь: Ногоон хөгжлийг бий болгох, экологийн баримжаатай эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг хангахын тулд Монгол орны ургамлын олон янз байдлыг судлах, хамгаалах, түүний генийн санг хадгалах, экологи биологийн онцлогийг эд, эс, бодгаль, популяци, экосистемийн түвшинд явуулж, ургамлын нөөц тогтоох, түүнийг зохистой ашиглах, нөөцийг нэмэгдүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах явдал юм.

Тус хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол орны ургамал нөмрөгийг илтгэсэн өвөрмөц бөгөөд олон улсын жишигт нийцсэн Ургамал судлалын музей, Оранжерея цогцолбор бүхий ботаникийн цэцэрлэгийг бүтээн байгуулах;
- Монгол орны ургамлын олон янз байдлыг судалж, бүртгэн цэгцэлж, цуглуулгын санг арвижуулан “Байгалийн ургамлын цуглуулгын үндэсний дижитал мэдээллийн сан” бий болгох;
- Монгол орны ургамлын үр, үрцэр, эд бүхий “Монгол орны байгалийн ургамлын генобанк” байгуулах;
- Монгол орны ургамалжил, ойн бүтэц, бүрэлдэхүүн, тархац, нөөцөд антропогенийн болон уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөг тогтоох урт хугацааны мониторинг судалгаа явуулах, цөлжилтийг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх, ургамал нөмрөгийн үнэлгээ хийх;
- Монгол орны ашигт ургамлын тархац, нөөц, биологи, экологийн онцлогийг судлан илрүүлж, нөөц баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, түүнд агуулагдах хоёрдогч метаболитын судалгаагаар инновацийн шинэ /эм, хүнс, бусад/ бүтээгдэхүүн бий болгох;
- Гадаад болон дотоодын гоёл чимэглэлийн, ашигт, ховор ургамлыг нутагшуулах, тарималжуулах, дасан зохицох механизмыг тогтоох, ган, хүйтэн өвчинд тэсвэртэй ургамлын суулгац, шинэ сортуудыг гаргаж авах зэрэг хамаарна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Архивын тухай хууль, Иргэний хууль, Шилэн дансны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд хүрээлэнгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- Сангийн сайдын 2025 оны А/03 тоот тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хүрээлэнд дотоод аудиторын орон тоо байхгүй, Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийдэг ба 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хүрээлэнгийн мөрдөж буй Монгол улсын Тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 26 өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-нь стандартад нийцсэн боловч үйл ажиллагааны онцлогт бүрэн тохирохгүй байна. Амьд цуглуулга буюу ховор ургамлын генофонд, модлог ургамлын үнэлгээ, эдгээрийн арчилгааны зардлыг бүртгэх нарийвчилсан аргачлалыг тусаагүй, “биологийн хөрөнгө”-ийн дахин үнэлгээ, судалгааны зардлыг капиталжуулах зааврыг шинэчлэх шаардлагатай байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

**Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 233,631.0 мянган төгрөгөөр буюу 28.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	108,000.0	53,300.0	(54,700.0)
Бараа материал	11,807.7	1,363.3	(10,444.4)
Үндсэн хөрөнгө	3,292,188.3	3,590,964.3	298,776.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,411,996.0</b>	<b>3,645,627.6</b>	<b>233,631.6</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,411,996.0	3,645,627.6	233,631.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,411,996.0</b>	<b>3,645,627.6</b>	<b>233,631.6</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснуудад байна. Үүнд:

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 54,700.0 мянган төгрөгөөр өссөн нь “Устаж болзошгүй нэн ховор, ховор ургамлын зүйлийг ех situ тарималжуулах, нөөцийг нэмэгдүүлэх” Шинжлэх ухаан технологийн сангийн цөм технологийн төслийн санхүүжилт 12,000.0 мянган төгрөг, “Модлог ургамлын биотехнологийн аргаар үржүүлэх судалгаа Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн төслийн санхүүжилт 41,300.0 мянган төгрөг, нийт 53,300.0 мянган төгрөгийн төслийн санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 10,444.4 мянган төгрөгөөр буурсан нь 88,406.5 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулж, тайлант хугацаанд 77,962.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 298,776.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд урсгал төсвийн санхүүжилтээр 452,576.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 25,247.8 мянган төгрөг, мөн 1,743.6 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг тус тус худалдан авсан нь нөлөөлсөн. Мөн ТӨБЗГ-ын 2025 оны 297, 815 дугаар тогтоолоор 75,099.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг данснаас хасаж, ашиглах хугацааг сунган, үнийг 23,082.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон, 309 дүгээр тогтоолоор 5,220.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталснаар буурчээ. Үүнээс биет бус хөрөнгийн үлдэгдэлд 1,500.0 мянган төгрөгийн санхүүгийн программ, 2,593,694.9 мянган төгрөгийн газар эзэмших 8 эрх бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэл 3,645,627.6 мянган төгрөг болж өмнөх оноос 233,631.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны 231,888.0 мянган төгрөгийн үр дүнгээс голлон нөлөөлсөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,162,423.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 1,422,593.4 мянган төгрөгөөр бууруулж, төсвийг 2,739,830.2 мянган төгрөгөөр баталсан нь тайлант оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,739,830.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,727,857.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 2,642,628.4 мянган төгрөгийг зарцуулж, 85,229.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,642,628.4 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 95,236.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71805	Шинжлэх ухаан, технологи нийт дүн	2,739,830.2	2,642,628.4	97,201.79	96.46
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,388,192.7	2,292,956.2	95,236.45	96.01
80219	Харуул, хамгаалалтын зардал	71,805.7	71,717.2	88.53	99.88
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	4,100.00	4,100.0	-	100.00
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	275,731.8	273,855.0	1,876.81	99.32

### 1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар

Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 328 дугаар тогтоолоор Ботаникийн хүрээлэнг татан буулгаж, ШУА-ийн харьяа Ботаникийн хүрээлэн болгон 63 орон тоотойгоор байгуулж 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааг нь эхлүүлсэн бөгөөд одоогийн байдлаар 58–60 албан тушаалтан ажиллаж байна. Ерөнхий сайдын албан даалгаврын дагуу 9 хувийн орон тооны цомхотгол хийгээгүй байна.

### 2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”, ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дугаартай “Цалин шинэчлэн тогтоох тухай” тушаалд нэг хүнд ногдох унааны зардлыг 1.0 мянган төгрөг, хоолны зардлыг 16.5 мянган төгрөг байхаар тус тус заасан байна.

### **3. Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн**

Тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний баг ШУТСангаас 2024-2026 онд хэрэгжүүлж буй “Устаж болзошгүй нэн ховор, ховор ургамлын зүйлийг ex situ нөхцөлд тарималжуулах, нөөцийг нэмэгдүүлэх” цөм технологийн төслийн хүрээнд БНХАУ-ын Шандун мужийн Линь И хотод ажилласан байна. Томилолтын хугацаанд 'Garden City' төслийн үйл ажиллагаатай танилцан туршлага судалж, мод сөөг, цэцэгт ургамлын үржүүлгийн дэвшилтэт технологийг эх орондоо нэвтрүүлэн ажиллаж байна. Уг төслийн нийт төсөв 120,000.0 мянган төгрөг бөгөөд гадаад томилолтын зардалд 8,800.0 мянган төгрөг зарцуулсан байна.

### **4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн.**

Тайлант онд хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 3,661.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, зарцуулсан байна. Үүнд:

- Ахмад эрдэмтэдтэй туршлага солилцох зорилгоор эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг залуу судлаач, оюутан залуусын дунд нээлттэй мэтгэлцээн, хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээний үр дүнд хүрээлэнгийн ахмад судлаачдын шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг олон нийтэд таниулж, санал зөвлөмжийг сонсон туршлага солилцсон үр дүнтэй ажил болжээ.
- Монгол хэлний тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хос бичигтэн болох зорилтыг тавьж, байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтын үр дүнд оролцогчид монгол бичгийн анхан шатны мэдлэг эзэмшсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 391,886.1 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, 335,833.5 мянган төгрөгийг зарцуулж, 56,052.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Үүнээс: цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд 57,088.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 4,621.1 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 44,952.1 мянган төгрөг, норматив-т зардалд 4,551.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 25,490.0 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 159,919.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,630.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд 37,580.7 мянган төгрөг, нийт 335,833.5 мянган төгрөгийг зарцуулсан.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь тайлант онд нийт 435,871.8 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны зарыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудсанд байршуулжээ.

Тайлант онд ШУА-ийн БЦХ/20250102001/02/01 дугаартай “Лабораторийн багаж, тоног төхөөрөмж худалдан авах” тендерт “Био Риажент” ХХК шалгарч, 177,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 31 нэр төрлийн 41 ширхэг иж бүрэн лабораторийн тоног төхөөрөмж, ШУА-ийн БЦХ/20250101002/03/01 дугаартай “Судалгааны суурин ба мониторингийн хашаа бариулах ажил” тендерт “ЭЭБТ” ХХК шалгарч, 255,871.8 мянган төгрөгийн төсөвт өртгөөр 4 нэр төрлийн судалгааны түр барилга болон хашаа, нийт 432,871.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Мөн урсгал төсвөөс 12,000.0 мянган төгрөгийн харуулын байр, 14,072.3 мянган төгрөгийн өвс хадагч өөрөө явагч, 2,180.0 мянган төгрөгийн ус цэвэршүүлэгч, нийт 28,252.3 мянган төгрөгөөр бусад үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төгсгүүд консалтинг аудит ХХК-ийн аудитор А.Саранцэцэг, аудиторын туслах Ч.Мандахтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Сарантуяа, компанийн захирал, аудитор Р.Даваа нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Тэгшсүрэн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аудит хийсэн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,806,514.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 28,065.4 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тэвчиж болох зардлуудыг гаргахгүй байх, зайлшгүй шаардлагатай зардлуудыг эрэмбэлэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан 32 заалтуудыг хамруулан горим сорил хэрэгжүүлсэн, аудитаар зөрчил илрээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 171 мэдээлэл байршуулахаас 170 мэдээлэл байршуулж, 1 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна. Цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш орлогын 2,504,684.9 мянган төгрөгийн 29 гүйлгээ, зарлагын 758,598.00 мянган төгрөгийн 34 гүйлгээг мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгийн данснуудад аудитын горим сорил хэрэгжүүлж, завсрын аудитаар 217,784.7 мянган төгрөгийн алдааг залруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 4,475.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 13,141.8 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	4,475.4	2	4,475.4	100.0
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	2	13,141.8	2	13,141.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>17,617.2</b>	<b>5</b>	<b>17,617.2</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны [finperform.mof.gov.mn](http://finperform.mof.gov.mn) сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
2. Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 131.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 131.9 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 27,933.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Төрийн албаны цалингийн нэгдсэн системд бодогдсон албан хаагчдын цалингаас 131.9 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгаж, төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна", 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгасан 131.9 мянган төгрөгийн нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн албаны цалингийн нэгдсэн системд бодогдсон албан хаагчдын цалингаас 131.9 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгаж, төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.	1	131.9	1	131.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>131.9</b>	<b>1</b>	<b>131.9</b>				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 70/A0150061

Улаанбаатар хот

САГ - 2026/47/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албаны цалингийн нэгдсэн системд бодогдсон албан хаагчдын цалингаас 131,900.00 ( нэг зуун гучин нэгэн мянга есөн зуун) төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгаж, төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7.1-т "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна", 7.1.1-т "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4.төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчдын цалингаас хувь хүний орлогын албан татварын 131,900.00 (нэг зуун гучин нэгэн мянга есөн зуун) төгрөгийг дутуу суутгаж, төсөвт төвлөрүүлээгүй нягтлан бодогч (Д.Номиндарь)-аар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирал /И.Түвшинтогтох/-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ТӨГСГҮҮД КОНСАЛТИНГ  
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

Р.ДАВАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Akt\2026\0225\_SAG-41.Docx

1526160510